

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2021 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 09 дүгээр сарын 30

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	Багануур дүүрэг ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	<ul style="list-style-type: none"> - Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих тухай МЕСЕС ХХК-тай байгуулсан гэрээний хүрээнд тус компанитай цахим уулзалт зохион байгуулан тулгамдсан асуудлыг хэлэлцэн тохиролцов. - Уг компани нь шугам барих бэлтгэл ажлыг хангаж байгаа талаар тодруулга хийсэн. Мөн манай байгууллагын хувьд хөрөнгө оруулалтын саналыг Нийслэл болон Эрчим хүчний яаманд хүргүүлэн ажилласан. 	100%
2.		Паркийн хүнд үйлдвэрийн бүсийн цахилгаан хангамжийн 35кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг 35/10 кВ-ын дэд станцын хамт барих хөрөнгө оруулалтыг дэмжин хамтран ажиллах боломжтой гадаад, дотоодын байгууллагыг судалж байна.	50%
3.		Ковид-19 халдварын тархалт эрчимтэй нэмэгдсэнтэй холбогдуулан төлөвлөгөөт уулзалтыг цуцалсан.	0%
4.		Коеус Консалтинг ХХК-аас ирүүлсэн нүүрсний хаягдлыг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийг хүлээн авч зөвлөмж өгч ажилласан. Мөн Багануур ХК-ийн нүүрснээс дээж авах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллав.	100%
5.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.2	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн зураг төсөл дуусч паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил эхлэх гэж байгаатай холбогдуулан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулах, Хөгжлийн стратеги төлөвлөлтөөр эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалтуудыг хугацаанд нь шийдвэрлүүлэх, байгууллагын үндсэн чиглэлийг өөрчлөхгүй байх саналуудыг НШУҮИГ-ын даргад 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 135 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100%
6.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.5	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн компост бордоог туршсан төв автомагистраль зам дагуух модны ургах явцад 09 дүгээр сарын 06-ны өдөр хяналт тавьсан.	100%
7.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.4	Албан бус-насан туршийн боловсролын төвөөс монгол бичгийн мэдлэг олгох сургалтыг авахаар болсон.	100%
8.	Нийслэлийн нутгийн захиргааны	Журмын дагуу дараах тайлангуудыг гаргаж холбогдох газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан. Үүнд:	100%

	байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт	<ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3 дугаар улирлын биелэлт 2. Багануур дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3 дугаар улирлын биелэлт 3. Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтын III улирлын тайлан 4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 3 дугаар улирлын мэдээ 5. Албан бичиг шийдвэрлэлтийн 3 дугаар улирлын мэдээ 	
9.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - 2021 оны 09 дүгээр сарын байдлаар хариутай 6, хариугүй 7 нийт 13 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4.69 - 2021 оны 09 дүгээр сарын байдлаар "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 13 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100% - 9 дүгээр сард ээлжийн амралт авсан 3 албан хаагчийн мэдээллийг ERP системд оруулж амралтыг бүртгэлжүүлсэн. 	100%
10.	ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол	<ul style="list-style-type: none"> - 2021 оны 09 дүгээр сарын байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 10, цар тахалтай холбоотой 19, цаг үеийн шинж чанартай 50 мэдээллийг байршуулсан. 	100%
11.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> - www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна. - Байгууллагын батлагдсан төсвийн дагуу сар, улирлын хуваарийг гаргаж зориулалтын дагуу зохистой зарцуулж байна. Сар бүрийн мэдээ, НД тайлан, татварын улирлын тайлан, санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж байна. 	100%
12.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1	<ul style="list-style-type: none"> - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. - Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна. - Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. - "Ковид 19 эрсдэл систем"-ийг бүх албан хаагчдад гар утсандаа суулган ашиглаж байна. - Бүх албан хаагчид коронавирусын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан. - 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд мэдээг шинэчлэн НЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажиллаж байна. 	100%

	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/477 дугаар захирамж, нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 593 дугаартай албан бичгээр өгсөн "Ковид-19 халдвараас сэргийлэх, батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед авах хариу арга хэмжээний түр зааварчилгаа"-ны хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
НЭМЭЛТ АЖИЛ		
13.	НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.	100%
14.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна.	100%
15.	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газартай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулахтай холбогдуулан НӨАУГ-аас 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад Газрын дарга, Нягтлан бодогч, Ахлах мэргэжилтэн нар оролцов.	100%
16.	Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний судалгааг нэгтгэн гаргахтай холбоотой зураг төсөл, ажлын зураг хийгдсэн, одоо хэрэгжиж байгаа болон хэрэгжээгүй төслийн талаарх мэдээллийг албан бичигт заагдсан хавсралт хүснэгтийн дагуу бэлтгэж erdeneoyun@ulaanbaatar.mn хаягаар хүргүүлсэн.	100%
17.	2021 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Багануур дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан "Байгууллагын харилцааны сэтгэл зүй" сэдэвт цахим сургалтад байгууллагын гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар зөвлөлийн гишүүд хамрагдсан.	100%
18.	Гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн зохион байгуулагдаж байгаа "Алдвал галдана" сарын аяны контент, шторк, постерыг албан хаагчдадаа таниулан, байгууллагын цахим хуудас болон ажилчдын нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна. Одоогийн байдлаар байгууллагын цахим хуудсаар 17 видео, 28 постерыг олон нийтэд түгээгээд байна.	100%
19.	Монгол Улсын Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27, 30 дугаар зүйлд заасан үүргийн хэрэгжилтийг ханган хэрэгжүүлсэн арга хэмжээний 3 дугаар улирлын тайланг "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 136 дугаартай албан бичгээр Багануур дүүргийн ИТХ-д хүргүүлсэн.	100%
20.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 46 дугаар захирамжийн хүрээнд холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан тухай тайланг 3 дугаар улирлын байдлаар гарган НЗДТГ-т 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 138 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН,
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.ЭЛБЭГСАЙХАН

Э.ЭНХЗАЯА

